

УДК 930.85+82(517.3)

МОНГОЛЫН ЭРТНИЙ УРАН ЗОХИОЛ ДАХЬ БАЙГАЛЬ, ЭКОЛОГИЙН СЭДВИЙН УЛАМЖЛАЛ

Wurigamala

МУИС-ын докторант, МонГУ, Улаанбаатар, Монгол Улс

E-mail: sugleg99@gmail.com

Товчлол

Зохиогч уг нийтлэлдээ туулийн зохиол, сайн сайхны ерөөл, магтаал, шүлгийн тодорхой жишээн дээр үндэслэн байгаль хамгаалал, экологийн сэдэвт монгол ардын аман зохиол, орчин үеийн яруу найргийн бүтээлийн ангилалыг толилуулжээ. Уул, мод газар дэлхий хөндөж мод огтлох, ургамлын үндэс сүйтгэх, амьтныг ихээр агнах, үүр ноохойг эвдэх зэргээр хилэгнүүлбэл савдаг уурлана, гол ус бохирдуулвал лус хилэгнэнэ гэх мэт номлол сургаал нь Монгол аман зохиолд төлөвшсөн байдаг. Өдгөө ч Монгол хүмүүст байгаль эхтэйгээ хэрхэн зүй зохистой харьцах үндсэн зарчим, чиг шугамыг тогтоож ард түмний дунд байгалиа дээдлэх, хайрлах, хамгаалах үзэл санаа энэ хэлбэрээр өнөө хүртэл оршин тогтнож байгаа билээ. Монголын эртний уран зохиолд эх дэлхий, уул, ус, тэнгэр газар, ургамал ногоо, ан амьтанг магтан дуулж, хайрлан хамгаалж ирсэн үзэл санаа маш их байдаг. Магтаал ерөөл, үлгэр домог, туульс зохиол, шүлэг яруу найрагт байгаль дэлхий, уул ус, ургамал ногоогоо хүндлэн дээдлэж, магтан биширсэн хэсэг гарах нь түгээмэл аж. Энэ нь хойч үедээ ан амьтнаа хайрлан хамгаалах, уул усаа “эзэнтэй”, “амьд” хэмээн дээдлэн онгон дагшинаар нь хадгалан хамгаалж ирэхэд их нөлөө үзүүлжээ. Өдгөө нь энэ үзэл санаа, уламжлал хэвээр байгаа бөгөөд Монголчууд бидний байгаль хамгаалах ойлголт мэдлэгийг гол суурь болж ирсэн байна.

Түлхүүр үг

Монголын эртний уран, гол бүтээлүүд, байгаль дэлхий, тэнгэр, нар сар шүтлэг бишрэл.

UDC 930.85+82(517.3)

TRADITIONS OF NATURE AND ECOLOGY THEMES IN ANCIENT MONGOLIAN LITERATURE

Wurigamala

PhD Student, National University of Mongolia, Ulaanbaatar, Mongolia

E-mail: sugleg99@gmail.com

Annotation

In this article, the author presents a classification of Mongolian folklore and modern poetic works on the themes of nature conservation and ecology, based on specific examples of epics, blessings, praise, and poems. The teachings of the Mongolian people, such as cutting down trees, destroying plant roots, hunting animals, and breaking nests, are well-established in Mongolian folklore. Even today, the Mongolian people have established basic principles and guidelines for how to properly interact with mother nature, and the idea of respecting, loving, and protecting nature has survived to this day. There are many ideas in ancient Mongolian literature that praise, love, and protect mother earth, mountains, water, heaven, earth, plants, and animals. It is common to find passages in praise, legends, epics, and poems that praise and admire nature, mountains, water, and plants. This has had a great influence on future generations to love and protect their animals, and to respect and protect their mountains and water as “owners” and “living” and to preserve them in their pristine state. Today, this idea and tradition remains, and it has become the main foundation of our Mongolian understanding of nature conservation.

Key words

Ancient Mongolian art, major works, nature, earth, sky, sun and moon worship.

Монголчуудын язгуур шүтлэг, домгийн сэтгэлгээнд байгалийг шүтэх шүтлэг тэнгэр, газар, ертөнцийн модны эрхэмнэлээр илэрдгийг судлаачид онцлон тэмдэглэсэн байдаг (Дамдинсүрэн, 2017; Цендина, 2014).

Жишээ нь, монголч эрдэмтэн С. Ю. Неклюдов “Хүннү, Ухуань нарын дунд ч гэсэн Хятадын сурвалжид (Бичурин, 1950: 49–50, 144; Сүхбаатар, 1971) өвөг дээдсийнхээ сүнс, тэнгэр, газар, нар, сар, оддыг хүндэтгэдэг тухай тэмдэглэсэн байдаг; дэлхийг тахин шүтэх нь байгалийн сэргэн мандалт (хавар), үржил шим (намрын) баяруудтай холбоотой байв” гэжээ (2019: 28).

Эртний киданчууд цагаан зүсмийн буга, нийт Монголчууд гоо марал, бөрт чоно, буриад монголчууд хун шувуу, ойрад Монголчууд уул шувуу гэхчлэн сүлд шүтээнээ болгодог байсан нь байгалийн нэгээхэн хэсэг болсон ан амьтныг хайрлах, хамгаалах сэтгэлгээг хойч үед төлөвшүүлэх нөлөөтэй байв.

Халимагийн монголч эрдэмтэн Э. У. Омакаева (2009; 2024) монгол хэлтэн нүүдэлчдийн цаг уур, одон орны мэдлэгийг ардын аман зохиол, уран сайхны зохиолд тулгуурлан цаг агаарын дискурс дахь байгалийн ландшафтын толинд судалдаг.

Монгол домогзүйн сэтгэлгээнд уул шүтлэг онцгой байртай. Эртний монголчуудын төсөөллөөр ертөнцийн төв цэг нь Сүмбэр уул гэж үзээд, тууль, үлгэртээ “Сүмбэр уулыг дов байхад, сүүн далайг шалбааг байхад” хэмээн өгүүлсээр ирсэн” гэсэн А. Алимаа, Д. Цэвээндоржийн “Байгаль, экологийн сэдэвт Монголын аман болон орчин үеийн яруу найргийн бүтээлүүд” сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэлд тэмдэглэсэнтэй (2020) санал нэг байгаа юм.

Монголын эртний уран зохиол дахь байгаль экологийн сэдвийн уламжлалыг аваад үзвэл, дараах байдлаар ангилан хуваан авч үзмээр санагдана.

Магтаал ерөөл

Хөгнө хааны магтаал
Хан Хөхүйн магтаал
Галын ерөөлийн судар
Гэрийн ерөөл
Гүүний сүүний цацлын судар

Үлгэр домог

Аргасан хуурчийн домог
Чойжид дагины тууж
Цаасан шувууны сургаал
Монгол туургатны үлгэр
Шидэт хүүрийн үлгэр
Хойд мэргэн тэвнийн домог

Шүлэг яруу найраг

Ардыг тэжээхүй рашааны дусал
Чингис хааны билиг
Эр хоёр загалын тууж
Оюунтүлхүүр
Богд Чингис хааныг магтан сургасан шаштир
Чингис хааны их өчиг

Туульс зохиол

Жангар

Гэсэр

Монголын нууц товчоо

Монголын Убаши хунтайжийн тууж

Магтаал ерөөл. “Монголын уран зохиолын философи бол ерөөсөө л нүүдлийн соёл иргэншил нь юм” хэмээн утга зохиол судлаачид тэмдэглэсэн байдаг. Энэ үүднээс авч үзэх юм бол Монголын уран зохиол эх дэлхий, уул, ус, тэнгэр газар, ургамал ногоо, ан амьтанг магтан дуулж, хайрлан хамгаалж ирсэн үзэл санаа маш их байдаг нь аргагүй юм. “Хөгнө хааны магтаал”, “Хан хөхүйн магтаал”, “Алтайн магтаал”, “Богд Дүнжингаравын магтаал” зэрэг уул, ус, хангай дэлхийгээ ширхэгчлэн магтан ерөөсөн төрөл бий. Магтаалуудын ерөнхий агуулгад уулсын сайхан байгаль, тэнд амьдардаг бүх ан амьтан, ургамал жимсийг төрөл төрлөөрөө, хад асга зэргийн янз бүрийн хэлбэр, рашаан булаг, ашигт малтмал, ер нь бүх баялгийг нь бишрэн магтаж байхдаа тодорхой дэс дараа, тогтолцоотой бөгөөд тухайлбал дөрвөн зүг, дөрвөн талаас нь үзэж магтах, дээрээс эхлээд доод хэсгийг нь хүртэл магтах, дөрвөн улирлын байдлаар салган ангилж магтдаг юм. Магтаалын төгсгөлд тухайн нутаг уул, хангайд хандан ийм сайхан, бүх хүмүүсийн хэрэгцээг хангаж, бүгдийг сайхан элбэг дэлбэг, аз жаргалтай байлгадагт талархаж байна гэсэн утгыг илэрхийлдэг аж. Жишээ болгож Магтаал ерөөлийн хэлбэртэй зохиол бүтээлүүдэд байгаль эх дэлхий, ан амьтан, араатан жигүүртнийг хэрхэн дүрсэлсэнг шинжлэх авч үзлээ. Дүрслэн магтаж буй хэлбэрээр нь мөн дараах дөрвөн хэлбэрт хуваасан.

- Дүрслэн магтсан
- Эд баялагийг тоочин магтсан
- Улирлын шинж байдлаар нь дүрсэн өгүүлсэн
- Сүсэглэн хүндэтгэсэн өнгө аястай

Хангай дэлхийгээ дүрслэн магтсан*Хаан буурал хангай л байна**Хасгийн улаан хадтай даа**Харанхуй бүргэд модтой доо**Хавчил жсалгаар олонтой доо**Хамаг амьтан цугларсан даа**Халх монголын нутаг юм байна.*

...

*Харлин Шарлин голтой доо**Хангидайн хадны зурагтай даа**Хадаасан, Чин дагуултай даа**Хар хүрмэн хадтай даа**Харбухын балгас, дурсгалтай даа**Хангайн дорнод нутаг л байна /Хөгнө хааны магтаал/***Эд баялагийг тоочин магтсан***Монос, торлог ихтэй дээ**Молор эрдэнийн сантай даа*

Могой гүрвэл элбэгтэй дээ
Морин шоргоолж олонтой доо
Мохошгүй зоригт эзэнтэй дээ
Монголын сайхан уул л байна
Алаг эрээн асгатай даа
Агуй хонгил элбэгтэй дээ
Аригуун сайхан арцтай даа
Алтан мөнгөн эрдэнэтэй дээ
Араатан гөрөөс олонтой доо
Аглаг өндөр хангай л байна /Хөгнө хааны магтаал/

...
Мөн цэцэрлэгийн дотор нь
Буга согооноос эхлэн
Бор, цагаан туулай
Бузгай олон гөрөөс
Босон хэвтэн сунналдаад
Сүлжилдээж гүйлдээж
Сүрэглэж нийлэлцээд байдаг билээ /Хан Хөхүйн магтаал/

Улирлын шинж байдлаар нь тодорхойлон дүрсэлсэн

Өвөл цагийн үед бол
Өтөг бууц нь дулаахан даа
Өтгөн балар шугуйдаа даа
Өвс бэлчээр сайтай даа
Өлөн зудыг үздэггүй дээ
Өнгөтэй сайхан нутаг л байна.

...
Намар болоод ирэхэд нь бол
Навчит мод magnaгласан даа
Найгаж ганхсан ойтой доо
Налж унасан ногоотой доо
Намираа шиврээ бороотой доо
Наагуур цаагуур нь үүлтэй л байна /Хөгнө хааны магтаал/

...
Хөрст алтан дэлхийн цасан хайлж,
Хөлдсөн бүгд гэсэн урсаж
Хөдөө талын өвс хөглөрч
Хөх бог нь дэлгэн гараад /Хан Хөхүйн магтаал/

Сүсэглэн хүндэтгэсэн өнгө аястай

Аяа!...
Цаглашигүй буян цогийг өгөн соёрхогч
Цаст уулсын эзэн нөхөр болсон
Цагаан зүгийг тэтгэн сахигч
Алдар сүр жавхлангаар түгээмэл учрал дэлгэрсэн

*Арван орны аливаа хишгийг хураагч
Авралын дээд Хан Хөхүй-юүгээн
Атгаггүй сэтгэлийн үүднээс
Алгасалгүй шүлэглэн магтаж өчсүгэй /Хан Хөхүйн магтаал/*

Лувсандондовын шүлэг зохиолоос олон нийтэд өргөн дэлгэрсэн томоохон уран бүтээл нь 400 гаруй мөр шүлэг бүхий "Хан Хөхүйн магтаал" гэдэг найраглал юм (1960; Загдсүрэн, 1970). Зохиолч энэхүү магтаал найраглалаа 1880 оны намар цаг Бүрэн хайрхан уулын оройд гарч 3 өдөр сууж бичсэн гэдэг яриа бий.

Дээрх магтаалаас гадна ерөөлүүд арай өөр хэв маяг, агуулгатай байна. "Гэрийн ерөөл", "Галын ерөөл", "Түүний сүүний цацлын ерөөл" зэрэг нь тус тусдаа шинж чанараар нь магтан ерөөх агаад ерөөл дотор байгаль эколгитой холбоотой хэсгийн тасдан авч үзлээ.

Сайн сайхан шинж чанаруудыг нь зүйрлэн тодотгохдоо "Хүч чадал эр зоригийг барс арслантай, үзэсгэлэн гоо бадамлянхуа цэцэгтэй, хамгийн дээд Хурмас тэнгэр, том агууг, сүмбэр уул, арвин ихийг сүн далай гэх мэтээр зүйрлэжээ. Гүүний сүүний цацалын сударт тэнгэр, газар нар, сар, уул уус нэгбүрчлэн магтан өргөжээ.

Туульсын зохиол

"Монголын уран зохиолын гурван их оргил" хэмээсэн "Монголын нууц товчоо", "Гэсэр", "Жангар" зэрэг эртний уран зохиолынхоо томоохон дурсгалууд дээр байгаль хамгаалал, уламжлал соёлын тухай хэрхэн тусгагдсанг анхааран авч үзсэн болно. Хүмүүн төрөлхтний шавхагдашгүй баян соёлын өв санд жинхэнэ ардын үлгэрч туульчдын амаар дамжин боловсорсон гайхамшигт аялгуу бүхий баатарлаг олон арван туулиудын дотроос яах аргагүй шигтгээ од мэт тод гялалзагч, ур утгын гайхам сэтгэмж, үг хэллэг бүхий жинхэнэ Монгол угсаатны зүй, зан заншил, аж ахуй, ёс суртахуун, түүх, хэл уран зохиол, дуун аяз, хүмүүний нийгэмшил, улс төрийн бодлого зэрэг бүхий л салбарыг багтаан тусгаж чадсан мөнхийн сод бүтээл бол баруун Монгол, Ойрад-Халимагийн алдарт тууль "Жангар" юм. Хүний амьдралын олон талыг тусгасан болохоор энэхүү тууль нь зөвхөн монгол туургатан улсуудын бус дэлхийн бүхий л ард түмний дур сонирхлыг их татдаг билээ. Жангар бол улс төр, шашин, Монголын ахуй амьдрал, түүх зэрэг бүхий л шинжлэх ухааныг өөртөө багтаасан яруу найраг хэлбэрээр бичигдсэн өв соёлын агуу бүтээл хэмээгддэг. Монгол туулийн хэл гайхамшигтай уран яруу бөгөөд монгол шүлгийн шилдэг уламжлалыг хадгалсан, эртний хэллэг, монголын олон ястан овогтны аман аялгууны онцлогийг агуулсан байдаг.

Монгол тууль нь Монгол ардын аман билгийн нэн эртний онцгой төрөл юм. Учир нь туульсийн бүтээлүүд нь эртний цадиг шүтлэг, бөө мөргөл, бурхны шашин, домог зүйн болон уран сайхны сэтгэлгээний олон үе давхрагыг хадгалсан байдаг. Үүн дотроо үлгэр, домог, ерөөл, магтаал, зүйр цэцэн үг, цацал мялаалга, бэлгэ дэмбэрлийн үг, дом шившлэг зэрэг аман зохиолын олон төрөл зүйлийг багтаана. Мөн хэдэн зуугаас хэдэн түмэн мөр шүлгээс бүрдэл болдог аварга том туурвил юм. Нэгэн шөнийн дотор багтаан хайлах бэсрэг туулиудаас гадна хэдэн шөнө дамнан хайлах дэлгэр тууль ч цөөнгүй бий.

Монгол туулийн хэл гайхамшигтай уран яруу бөгөөд монгол шүлгийн шилдэг уламжлалыг хадгалсан, эртний хэллэг, монголын олон ястан овогтны аман аялгууны онцлогийг агуулсан байдаг. Үүнээс гадна тууль нь зөвхөн үгийн урлаг төдийгүй хөгжим аялгуу, туульчийн уран чадвар, хайлах, хэлэх ёс жаяг, зан үйлийг багтаасан нийлмэл урлагийн шинжтэй цогц үзэгдэл юм. Монгол туулийн гурван сүмбэр оргил нь “Жангар”, “Гэсэр”, “Алтайн магтаал”. Гэсэр хааны тууль: Эдүгээ хүртэл ардын хэдэн зуун уран сайханчид Түвд, Өвөр Монгол, Хөхнуурт Гэсэр баатарын үйл явдлыг уламжлан дуулсаар байна. Гэсэр хааны тууж нь НТӨ 100-300 оноос НТ ҮI зууны үеийн хооронд үүсч бүрэлдсэн бөгөөд мянга шахам жилийн урт хугацаанд ардын уран сайханчдын ам дамжин уламжлагдах явцдаа үйл явдал, хэлц хэллэг нь тасралтгүй баяжин хөгжиж ирсэн. уулийн агуулгаас дурьдвал: Эрт цагт Түвдийн газар бүхэнд мангас чөтгөр бий болж, ард иргэд гал усны гаслан зовлон амсаж байжээ. Энэрэнгүй нигүүлсэнгүй хомьсон бодьсатва хамаг амьтныг аврахын тулд тэнгэрийн сахиусан хөвгүүнийг тоост ертөнцөд туслуулахаар илгээжээ. Сахиусан хөвгүүн Туйбагава хувилан төрж Түвдчүүдийн эзэн богд Гэсэр хаан болжээ. Гэсэр хаан мангас чөтгөрүүдийг дарж, ард иргэдэд жаргалыг эдлүүлэх үүрэг хүлээж, онцгой зан чанар, ер бусын хүчин чадал олж, гурван хувилгаан сахиусыг биедээ нэгтгэж хагас сахиусан, хагас хүний дүртэй баатар болон хувирчээ. Гэсэр хаан олон саад бэрхшээл, ад зэтгэрийг давж, авъяас чадлаа бадруулан, дайн хийж дөрвөн зүгийн дайсныг эрхэндээ оруулжээ. Гавьяа зүтгэлээрээ бүрэн төгс ялалтыг байгуулж өөрийн эх, хатан зэрэг хүмүүсээ авч тэнгэрийн орондоо буцсанаар үйл явдал өндөрлөдөг. Гэсэр хааны тууж нь нийт 120 гаруй бүлэг, сая гаруй мөр шүлэг, 20 сая үгтэй ажээ.

Жангарын тууль: “Жангар” бол монгол туулийн оргил юм. ХҮ зууны үед Ойрадын ард түмний дунд зохиогдож, нийт монголчуудын дунд тархсан ардын аман зохиолын нэг төрөл болох баатарлаг тууль юм. 2006 онд Т.Галсан “Монгол Жангар” хөлгөн их судрын хоёр ботийг хэвлүүлжээ. Жангар туульд Монгол угсаатны зүй, зан заншил, аж ахуй, ёс суртахуун, түүх, хэл уран зохиол, дууны аяз, хүний нийгэмшил, улс төрийн бодлого зэрэг бүхий л салбарыг багтаан тусгаж, яруу найраг хэлбэрээр бичсэн аман зохиолын чухал өв соёл учраас зөвхөн монгол туургатан улсуудын бус дэлхийн олон ард түмний сонирхлыг татаж, олон судлаач эрдэмтэдийн судлагдахуун болжээ.

Туулийн нийтлэг өгүүлэмж нь Жангарын өөрийн цадиг намтар, орон нутаг, өргөө гэр, дайчин нөхөд, гавьяат үйл бүтээлийг нь ерөнхийлөн дурдсан удиртгал чанартай эхлэлээс гадна олон бүлэг бүхий том хэмжээний баатарлаг тууль юм. Зохиолын “Эхлэл” хэсэгт Жангар баатар эрхэн 2 насандаа догшин мангаст нутгаа дайлуулж, өнчин биеэр үлдсэн боловч 3 насандаа Гулжин их мангасыг номдоо оруулж, 4 насандаа Дөрдөн шар мангасыг номхотгож, 5 насандаа Тахийн таван шулам хааныг олзолж, 6 насандаа зуун жадын үзүүр хугалж, Хүнхээн Алтан Цээж баатрыг эрхэндээ оруулж, энгийн олон баатруудынхаа барууны ахлаач болгож, долоотойдоо доордын долоон орныг доройтуулж, дуутай Жангар нэрээ дурсган, дөрвөн зүгийнхээ дөчин хааны нутгийг номдоо оруулж, тивийн дөрвөн хааны хүүхнүүдийг голоод, нар гарах, үд хоёрын хооронд байдаг Ном төгс хааны охин Агай Шавдалтай гэрлэн, үргэлжид хорин таван настай дүрээрээ, үхэлгүй мөнхийн Бумба орныхоо арван давхар, есөн өнгийн алтан торлог байшиндаа төр шажин хоёроо зарлиг болоод сууж байгаа тухай өгүүлсэн байдаг. Туулийн гол үзэл санаа нь эх нутаг, улс үндсээ хамгаалахыг ухуулсан зохиол юм

Жангар туужид

Өвөлгүй хаврын хэвээр

Зунгүй намраар

Даарах хүйтэнгүй

Халах халуунгүй

Сэр сэр гэсэн салхитай

Бур бур гэсэн хуртай Бумбын орон болно

хэмээн улирал цагийн аясыг магтан дүрсэлж, уул, ус, далай, нар сарыг дүрслэн магтсан хэсэг цөөн боловч бий.

Гэсэр туужид Хурмаст тэнгэр, хувилгаан тэнгэр гэх мэт зүйлс гарах бөгөөд ид шид, илбэ чадвартай бүхийг чадагч хамгийн хүчирхэг тэнгэрийн эзэд хэмээн дүрслэгдэнэ. Дайн тулаан зөрчил тэмцэл өгүүлэх Монголын эртний уран зохиолын дээрх бүтээлүүдэд байгаль орчин хайрлан хамгаалах санаа гэхээсээ илүү шүтэн биширсэн, хүндлэн дээдэлсэн, залбиран мөргөсөн агуулга хэсэг гарч байна. Ертөнцөөс хэдийдсэн мөн чанар, бүхнийг болгоогч чадвар зэрэг өнөөгийн бидний ойлголь мэдлэгээс их өөрөөр илэрхийлэн дүрсэлсэн байна. Энэ нь өдгөө ч байгаль хамгаалалтын уламжлалт ойлголт болон ирсэн ба судлаачид үүнийг “сүсэг бишрэлийн өнгө аястай” хэмээн тодорхойлон ангилсан нь бий.

Шүлэг яруу найраг

Хоёр ёсыг номлосон шастир **Ардыг тэжээхүй рашааны дусал** хэмээх яруу аялгуу үүнийг их багш хутагт Нагаржуна гэгээнтэн зохиосон (Дамдинсүрэн, 1960).

XIX зууны эхэн хагаст ноён хутагт Равжаа гэдэг шүлэгч байжээ (Ганхуяг, 2011; Suglegmaa, Tumurbaatar, 2021). Анх Ц.Дамдинсүрэн 1959 онд хэвлүүлсэн “Монголын уран зохиолын дээж зуун билиг” хэмээх номдоо Д.Равжаагийн зохиосон “Цагийн жамыг тодруулагч цаасан шувуу”, “Дөрвөн улирал”, “Тэргэл сарны гэрэл” зэрэг шүлгийг тусгай тайлбартай хамт хэвлүүлжээ.

ДҮГНЭЛТ

Монголын эртний уран зохиолын том бүтээлүүд болох “Монголын нууц товчоо”, “Гэсэр”, “Жангар”-ын тууль, уул уулсны магтаалууд, үлгэр домог туульс бүтээлүүдэд тэнгэр, нар, сар, уул, ус ан, амьтан жигүүртэнг шүтсэн, дээдэлсэн, хүч чадал, ундарга, эхлэл гэх мэтээр сайн сайхан бүхний төлөөлөл билэгдэл болгон харуулж байгаа нь харагдсан. Мөн Монголчууд эртнээс бөө мөргөлийг шүтдэг байлаа. Бөө мөргөлийн соёлд “Галын тахилга”, “Уул усны тахилга”, “Тэнгэрийн тахилга” магтаал шүлэг бий. Нүүдэлчин соёлын мөн чанар нь байгалиа сүйтгэдэггүй, хэвээр хадгалах эрмэлзэл юм. Байгальтай харьцах бидний уламжлалт соёл өдгөө хүн төрөлхтний нэн ховор үнэт зүйл болсон байна. Дэлхийн өндөр хөгжилтэй улс орнууд байгаль экологийн тэнцвэрт байдалд түшсэн эдийн засаг, хөгжлийн бодлогыг эрмэлзлэх болсон.

Магтаал ерөөл, үлгэр домог, туульс зохиол, шүлэг яруу найрагт байгаль дэлхий, уул ус, ургамал ногоогоо хүндлэн дээдлэж, магтан биширсэн хэсэг гарах нь түгээмэл аж. Энэ нь хойч үедээ ан амьтнаа хайрлан хамгаалах, уул усаа “эзэнтэй” “амьд” хэмээн дээдлэн онгон дагшинаар нь хадгалан хамгаалж ирэхэд их нөлөө үзүүлжээ. Өдгөө нь энэ үзэл санаа, уламжлал хэвээр байгаа бөгөөд Монголчууд бидний байгаль хамгаалах ойлголт мэдлэгийг гол суурь болж ирсэн байна.

Ашигласан материал:

Монгол туургатны үлгэр /тэргүүн дэвтэр/.

Арван зүгийн арван хорын үндсийг тасалсан ачит богд Гэсэр мэргэн хаан алдаршин дуурссан /тэргүүн бүлэг/.

Шидэт хүүрийн үлгэр.

Хойт мэргэн тэвнийн домог.

Монголын нууц товчоо.

Галын ерөөлийн судар.

Аргасун хуурчийн домог.

Хоёр загалын тууж.

Н о м з ү й

Алимаа, А., Цэвээндорж, Д. (2020). Байгаль, экологийн сэдэвт монголын аман болон орчин уеийн яруу найргийн бүтээлүүд (= Произведения устной и современной поэзии о природе и экологии). *Бюллетень Калмыцкого научного центра РАН*. 2 3. 189–206.

Бичурин, Н.Я. (Иакинф) (1950). Собрание сведений о народах, обитавших в Средней Азии в древние времена. I–III. Москва; Ленинград: Изд-во АН СССР.

Ганхуяг, Н. (2011). XIX зууны суут соён гэгээрүүлэгч Д. Равжаагийн Цаасан шувуу тэргүүт алтан сургаал. Улаанбаатар: Китаб.

Дамдинсүрэн, Ц. (1960). *Ардыг тэжээхүй дусал нэрт шаадирын тайлбар Чандманийн чимэг*. CSMT. Fasc. 2. Улаанбаатар.

Дамдинсүрэн, Цэндийн (2017). *Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган IV боть. Монгол уран зохиолын дээж зуун билиг оршой (Нэгдүгээр дэвтэр)*. Эрхлэн хэвлүүлсэн А. Д. Цендина, Р. Отгонбаатар. Хөрвүүлж, хэвлэлд бэлтгэсэн А. Амарсанаа, Н. Бямбасүрэн. Улаанбаатар.

Загдсүрэн, У. (1970). Хан Хөхуйн магтаал. *Монголын судлал*. *Studia mongolica Instituti linguae et litterarum Academiae scientiarum Reipublicae populi Mongolici*. VII (10). 119–132.

Лувсандондов, С. (1960). Хан Хөхуйн магтаал. "Цог" сэтгүүл. 1.

Неклюдов, С.Ю. (2019). *Фольклорный ландшафт Монголии. Миф и обряд*. Москва: Индрик.

Омакаева, Э. У. (2009). Фольклорный поэтический текст монголоязычных народов сквозь призму этнолингвистических и кросс-культурных контактов: история и современность. *Прошлое и настоящее монгольских народов*: Олон улсын эрдэм шинжилгээний хоёрдугаар чуулган = Материалы II международной конференции, Улаанбаатар, 28–30 августа 2007 года / Research Institute for languages and cultures of Asia and africa Tokyo University of Foreign Studies = Исследовательский институт языков и культур Азии и Африки, Токийский университет зарубежных исследований. Улаанбаатар: Исследовательский институт языков и культур Азии и Африки. 342–351.

Омакаева, Э. У. (2024). Метеорологические и астрономические знания монголоязычных кочевников в зеркале природно-ландшафтного лексикона в погодно-климатическом дискурсе: на материале фольклорных и художественных текстов. *Nomadic Civilization: Historical Research*. 4(2). 105–114. DOI 10.53315/2782-3377-2024-4-2-105-114.

Сүхбаатар, Г. (1971). *Сяньби*. Улаанбаатар: ШУАХ.

Сүхбаатар, Г. (1980). *Хунну*. Улаанбаатар: ШУАХ.

Цендина, А. Д. (2014). Академик Цэндийн Дамдинсүрэн и коллекция его книг. *Страны и народы Востока*. 35. 359–370.

Suglegmaa, Kh. (2021). Scientific research works on the prominent poet of Mongolia Danzan Ravjaa in the world's Mongolian Studies / Kh. Suglegmaa, M. Tumurbaatar. Eurasian Union of Scientists. Series: Philology, Art History and Cultural Studies. 5(86). 10–14.

References

Alimaa, A., Tsevēndorj, D. (2020). Works of Mongolian oral and modern poetry on nature and ecology. Bulletin of the Kalmyk Scientific Center of the Russian Academy of Sciences. 2 3. 189–206.

Bichurin, N.Ya. (Iakinf) (1950). Collection of information about the peoples living in Central Asia in ancient times. I–III. Moscow; Leningrad: Publishing House of the Academy of Sciences of the USSR.

Cendina, A. D. (2014). Damdinsuren and the collection of Akademik Tsendin's book. Vostok of the country and people. 35. 359–370.

Damdinsuren, Ts. (1960). The Interpretation of the Famous Shashdir Chandmaniyin Chimeg. CSMT. Fasc. 2. Ulaanbaatar.

Damdinsuren, Ts. (2017). Conference of scientific works, volume IV. Mongolian literature sample, hundred bilig orshvoy (First volume). Published by A. D. Tsendina, R. Otgonbaatar. Translated and prepared for publication by A. Amarsanaa, N. Byambasuren. Ulaanbaatar.

Gankhuyag, N. (2011). The Golden Teachings of the Great Enlightener of the 19th Century D. Ravjaagiin, The Paper Kite. Ulaanbaatar: Kitab.

Luvsandondov, S. (1960). Praise of Khan Khokhuyin. "Tsog" magazine. 1.

Neklyudov, S.Yu. (2019). Folklorny landscape of Mongolia. Myth and ritual. Moscow: Indrik.

Omaeva, E. U. (2009). Folkloric poetic text of Mongolian nations through the prism of ethnolinguistic and cross-cultural contacts: history and modernity. Прошлое и настоящее монгольских народов: The Second International Research Conference = Material II International Conference, Ulaanbaatar, August 28-30, 2007 / Research Institute for languages and cultures of Asia and Africa Tokyo University of Foreign Studies Ulaanbaatar: Issledovatel'skiy Institute of Languages and Cultures of Asia and Africa. 342–351.

Omaeva, E. U. (2024). Meteorological and astronomical knowledge of Mongolian nomads in the mirrors of the natural-landscape lexicon and weather-climatic discourse: on the material of folkloric and artistic texts. Nomadic Civilization: Historical Research. 4(2). 105–114. DOI 10.53315/2782-3377-2024-4-2-105-114.

Suglegmaa, Kh. (2021). Scientific research works on the prominent poet of Mongolia Danzan Ravjaa in the world's Mongolian Studies / Kh. Suglegmaa, M. Tumurbaatar. Eurasian Union of Scientists. Series: Philology, Art History and Cultural Studies. 5(86). 10–14.

Sukhbaatar, G. (1971). Xianbi. Ulaanbaatar: SHUAH.

Sukhbaatar, G. (1980). Hunnu. Ulaanbaatar: SHUAH.

Zagdsuren, U. (1970). Praise of Khan Khokhuyin. Mongolian studies. Studia mongolica Instituti linguae et litterarum Academiae scientiarum Reipublicae populi Mongolici. VII (10). 119–132.